



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 454

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 68,900,000.00 (жаран найман сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 20,095,831.00 (хорин сая ерэн таван мянга найман зуун гучин нэгэн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Батболд, гүйцэтгэх захирал Д.Баттөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлэн бүртгүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

300890

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2020 оны  
09 дүгээр сарын 22-ний өдрийн  
454 дугаар тогтоолын хавсралт

**"МИАТ" ТӨХК-иас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын балансад шилжүүлэх  
үндсэн хөрөнгийн жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиг лал танд орсон он	Тоо шир хэг	Балансын дүн (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэг дэл өртөг (төгрөг)
1	Хьюндай Соната-8 маркийн, 81-09 УБУ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар - КМНЕ241СВКА510705	10/01/18	1	68,900,000.00	20,095,831.00	48,804,169.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1 (нэг)</b>	68,900,000.00 (жаран найман сая есөн зуун мянган)	20,095,831.00 (хорин сая ерэн таван мянга найман зуун гучин нэгэн)	48,804,169.00 (дөчин найман сая найман зуун дөрвөн мянга нэг зуун жаран есөн)